

ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 2022 ОНЫ АВИЛГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, төсөвт байгууллага/



Захиалагч байгууллага : Өмнөговь аймаг Засаг даргын тамгын газар

2022 он

Хүснэгтийн жагсаалт

1. Өмнөговь аймгийн ЗДТГ-ын дэргэдэх агентлаг, төсөвт байгууллагуудаас мэдээлэл цуглуулсан байдлын бүртгэл
2. Авилгын эсрэг авч хэрэгжүүлсэн ажил, үйл ажиллагааны гүйцэтгэлийн ерөнхий үр дүн ажлын агуулгаар
3. Авилгын эсрэг хууль, тогтоомжийг сурталчилсан байдлын үнэлгээ
4. Бодлого боловсруулалтанд олон нийтийн оролцоог хангасан байдлын үнэлгээ
5. Төсөв, санхүүгийн ил тод байдал
6. Хяналтын үйл ажиллагааны ил тод байдал
7. Зөвшөөрөл бүртгэлийн ил тод байдлын үнэлгээ
8. Хүний нөөцийн ил тод байдлыг хангасан байдал
9. Худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан байдал
10. Албан хаагчдын ажил үүргийн хувиарыг тодорхой болгосон байдал
11. Удирдлагын шийдвэрийн ил тод байдлын үнэлгээ
12. Иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн үнэлгээ
13. Авилгын эрсдэлийг бууруулах боломж, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны гүйцэтгэлийн үзүүлэлт ба үр дүн
14. Удирдлагын авилгатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, гүйцэтгэлийн үзүүлэлт ба үр дүн
15. Төрийн байгууллагуудын ил тод, шудрага байдлын үнэлгээ, гүйцэтгэлийн үзүүлэлт ба үр дүн

Тайлангийн агуулга

1.Удиртгал	4
1.1 ҮНЭЛГЭЭНИЙ ХУУЛЬ ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ	4
2.Үнэлгээний арга зүй	5
2.1 ЗОРИЛГО, ЗОРИЛТ	5
2.2 ХАМРАХ ХҮРЭЭ, АНГИЛАЛ	5
3.үнэлгээний үр дүн	7
3.1 ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СУРТАЛЧИЛГАА	10
3.2 БОДЛОГО БОЛОВСРУУЛАЛТ ДАХЬ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО	11
3.3 ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ	12
3.4 ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	12
3.5 ЗӨВШӨӨРӨЛ БҮРТГЭЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	15
3.6 ХҮНИЙ НӨӨЦИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	15
3.7 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ	16
3.8 АЛБАН ХААГЧДЫН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ	17
3.9 УДИРДЛАГЫН ШИЙДВЭРИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	18
3.10 ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ	18
3.11 АВИЛГЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ БОЛОМЖ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	19
3.12 УДИРДЛАГЫН АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ХҮСЭЛ ЭРМЭЛЗЛЭЛ	19
3.13 ТӨРИЙН БАЙГУУЛАГУУДЫН ИЛ ТОД, ШУДРАГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	21
4.Дүгнэлт	22
6.Хавсралт материал	23

1.УДИРТГАЛ

Авлигатай тэмцэх газраас төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор Монгол улсын засгийн газартай хамтран яам, агентлаг, аймаг нийслэлийн түвшинд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Түүнчлэн Авлигатай тэмцэх газар (АТГ) нь 2013 оноос энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал, хүрсэн үр дүн, тухайн байгууллагын тухайн жилийн авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хараат бус шинжээчдийн багийг шалгаруулах замаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, үр дүнг олон нийтэд хүргэж байна.

Говь эвент ХХК-ны шинжээчдийн баг нь 2022 оны Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, төсөвт байгууллагуудын авлигын эсрэг авч хэрэгжүүлсэн ажил үйлчилгээ болон гүйцэтгэлд, дүн шинжилгээ хийх зорилготой ажиллаа.

1.1 Үнэлгээний Хууль Эрхзүйн Үндэслэл

Үнэлгээний ажлыг гүйцэтгэхдээ АТГ-ын даргын “Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ыг баримталж ажилласан бөгөөд дараах хууль эрх зүйн баримт бичгийг үндэслэл болгосон.

1. Авлигын эсрэг хууль:

- ✓ 18 дугаар зүйл. 18.1.1. улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
- ✓ 18 дугаар зүйл. 18.1 4. Төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авах;
- ✓ 18 дугаар зүйл. 18.4.4. авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилтай холбогдуулан төрийн байгууллагаас холбогдох мэдээ, судалгаа, тайлан гаргуулан авах;
- ✓ 18.4.14. хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, мэдээлэл өгөх журмын биелэлтийг шалгах.

2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль:

- ✓ 28 дугаар зүйл. 28.1. Энэ хуулийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрхэн дагаж мөрдөж байгаад дараах байгууллага хяналт тавина:
- ✓ 28.1.2. энэ хуулийн 28.1.1-д зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газар хяналт тавина.

2. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

2.1 Зорилго, зорилт

Засаг даргын дэргэдэх агентлаг, төсөвт байгууллагуудын авилгын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх авилга бий болох шалтгааныг тодорхойлох зорилготой дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан.

- Авилгын шалтгааныг тодруулах, авилгыг зогсоох үйл ажиллагааны чиглэл гаргах
- Тухайн байгууллагуудын үнэлгээг нэмэгдүүлэх зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлох
- Үнэлгээний үр дүнд суурилан байгууллагуудын авилгын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлыг нэмэгдүүлэх дүгнэлт гаргах.

2.2 Хамрах хүрээ, ангилал

Үнэлгээнд нийт Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх 25 агентлаг, 11 төсөвт байгууллагаг хамрууллаа. Эдгээр байгууллагуудын авилгын эсрэг тухайн жилд авилгын эсрэг авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг дараах аргачлалын дагуу үнэлж, шинжилгээ хийлээ.

- **Цахим хуудсын үнэлгээ:** Тухайн байгууллагын албан ёсны цахим хуудаст ажиглалт хийн зориулалтын үнэлгээний хуудас бөглөсөн. Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх 25 агентлаг, 11 төсөвт байгууллагын албан ёсны цахим хуудаст ажиглалт хийсэн бөгөөд бүх байгууллагын цахим хуудсыг хамарч чадсан.
- **Асуумж судалгаа:** Авилгын эсрэг удирдлагын хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт үлгэр жишээ байдал, бууруулах боломж бололцоо өнөөгийн нөхцөл байдлын үнэлэлтийн талаар анкет судалгаа авсан. (Биечлэн очих болон онлайн сүлжээ ашиглах гэсэн 2 төрөл). Нийт аймгийн Засаг даргын дэргэдэх 25 агентлаг, 11 төсөвт байгууллагын 258-н албан хаагч 750 иргэд судалгаанд хамрагдаж удирдлагын ажлын нөхцөл байдалд үнэлгээ өглөө.

Аргачлалын дагуу судалгааны мэдээлэл цуглуулсан байдлыг дараах хүснэгтээр дэлгэрүүлэн харуулав.

Хүснэгт 1. Өмнөговь аймгийн ЗДТГ-ын дэргэдэх агентлаг, төсөвт байгууллагуудаас мэдээлэл цуглуулсан байдлын бүртгэл

№	Агентлаг, төсөвт байгууллагуудын нэрс	Веб мониторинг	Асуумж судалгаа
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газар (пэйж хуудас)	1	28
2	Биеийн тамир, спортын газар	1	28

3	Боловсрол, шинжлэх ухааны газар	1	28
4	Гаалийн алба	1	28
5	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	1	28
6	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	1	28
7	Мал эмнэлгийн газар	1	28
8	Мэргэжлийн хяналтын газар	1	28
9	Нийгмийн даатгалын хэлтэс	1	28
10	Онцгой байдлын газар	1	28
11	Орон нутгийн өмчийн газар	1	28
12	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	1	28
13	Соёл, урлагийн газар	1	28
14	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	1	28
15	Статистикийн хэлтэс	1	28
16	Татварын хэлтэс /вэб хуудас/	1	28
17	Улсын бүтргэлийн хэлтэс	1	28
18	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	1	28
19	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	1	28
20	Хүнс, хөдөө аж ахуйн газар	1	28
21	Цагдаагийн газар/вэб,пэйж хуудас/	1	28
22	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	1	28
23	Шүүхийн шинжилгээний алба	1	28
24	Эрүүл мэндийн газар /вэб хуудас/	1	28
25	Авто тээврийн үндэсний төвийн өмнөговь аймаг дахь салбар	1	28
26	Музей	1	28

27	Хөгжимт жүжгийн театр	1	28
28	Номын сан	1	28
29	Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газар	1	28
30	Даланзадгад зорчигч тээвэр ОНӨГААТГ	1	28
31	Хөгжил, хөрөнгө оруулалтын газар	1	28
32	Төрийн үйлчилгээний алба	1	28
33	"Буянт хотхон" УТҮГ	1	28
34	Ойн анги	1	28
35	Насан туршийн боловсролын төв	1	28
36	АЙМГИЙН ЗДТГ	1	20
Нийт		36	1000

Мэдээллийн сан бүрдүүлэлт ба ашиглалт

Үнэлгээний ажлын хүрээнд дараах төрлийн мэдээллийн сан бүрдсэн. Үүнд:

- ✓ Аймгийн Засаг даргын дэргэдэх 25 агентлаг, 11 төсөвт байгууллагын албан ёсны цахим хуудсанд хийсэн үнэлгээний тэмдэглэл. /MS excel/
- ✓ Албан хаагчдаас цуглуулсан асуумж судалгааны мэдээлэл. / MS excel, /
- ✓ Үнэлгээнд хамрагдсан албан хаагч болон судалгаанд хамрагдса иргэд бүрийн нарийвчилсан мэдээллийг агуулсан нэгдсэн үнэлгээний тэмдэглэл. /MS excel/

Судалгааны мэдээллийн бүрэн бүтэн, найдвартай байдлыг хангахын тулд, агуулгын хяналт, утсан хяналт, мэдээлэл оруулалтын хяналт гэх мэт мэдээллийн чанарын хяналтуудыг гүйцэтгэсэн.

Дээрх мэдээллийн сангуудыг ашиглан мэдээлэл бүрийн дунжийг бодох, эрэмбэлэх зэрэг аналитик үр дүнгүүдийг мэдээлэл боловсруулалтын SPSS программыг ашиглан гаргаж, тайланд тусгалаа.

3. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Шинжээчдийн багийн зүгээс “ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 2022 ОНЫ АВИЛГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ”-нд 13-н дэд үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийлээ.

Аргачлалд тусгагдсан үзүүлэлт тус бүрт гүйцэтгэл хангалттай байгаа тохиолдолд аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагууд, төсөвт байгууллагууд тус бүр 40 оноогоор үнэлэгдэх боломжтой. Тус үнэлгээнд байгууллагууд 19 онооны дундажтай үнэлэгдэж



байна. Үнэлгээний дундаж үзүүлэлт доош татагдах гол шалтгаан нь байгууллага агентлагуудын мэдээллийн ил тод байдалтай холбоотой байлаа.

Ерөнхий дундаж үзүүлэлттэй харьцуулахад үзүүлэлт тус бүрийн хувьд ямар үр дүн харуулж байгааг дараах хүснэгтээр харуулахыг зорив.

- *Ерөнхий дунджаас дээш үр дүн харуулсан. Цаашид байгууллагууд энэ үр дүнгээ бататгах, хадгалж үлдэх арга хэмжээ авбал зохино.*
- *Ерөнхий дундажтай ойролцоо үр дүн харуулсан. Цаашид байгууллагууд анхаарч сайжруулах шаардлагатай.*
- *Ерөнхий дунджаас доош үр дүн харуулсан. Цаашид байгууллагууд гүйцэтгэлийг сайжруулах тал дээр эрс сайжруулалт хийх шаардлагатай.*

Хүснэгт 2. Авилгын эсрэг авч хэрэгжүүлсэн ажил, үйл ажиллагааны гүйцэтгэлийн ерөнхий үр дүн, ажлын агуулгаар

№	Хийх ажлын агуулга	Гүйцэтгэл
1.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах	●
2.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох	●
3.	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах	●
4.	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх	●
5.	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах	●
6.	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	●
7.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	●
8.	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	●
9.	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	●
10.	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах	●
11.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	●

12.	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт	
13.	Төрийн байгууллагуудын ил тод, шударга байдлыг нэмэгдүүлэх	

№	Агентлаг, төсөвт байгууллагуудын нэрс	Тус бүрийн оноо	Нийт оноо
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газар (пэйж хуудас)	25	40
2	Биеийн тамир, спортын газар	8	40
3	Боловсрол, шинжлэх ухааны газар	25	40
4	Гаалийн алба	0	40
5	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	25	40
6	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	23	40
7	Мал эмнэлгийн газар	25	40
8	Мэргэжлийн хяналтын газар	30	40
9	Нийгмийн даатгалын хэлтэс	22	40
10	Онцгой байдлын газар	28	40
11	Орон нутгийн өмчийн газар	12	40
12	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	27	40
13	Соёл, урлагийн газар	8	40
14	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	21	40
15	Статистикийн хэлтэс	26	40
16	Татварын хэлтэс /вэб хуудас/	26	40
17	Улсын бүтргэлийн хэлтэс	26	40
18	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	23	40
19	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	14	40
20	Хүнс, хөдөө аж ахуйн газар	11	40

21	Цагдаагийн газар/вэб,пэйж хуудас/	29	40
22	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	15	40
23	Шүүхийн шинжилгээний алба	23	40
24	Эрүүл мэндийн газар /вэб хуудас/	26	40
25	Авто тээврийн үндэсний төвийн өмнөговь аймаг дахь салбар	25	40
26	Музей	23	40
27	Хөгжимт жүжгийн театр	22	40
28	Номын сан	23	40
29	Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газар	14	40
30	Даланзадгад зорчигч тээвэр ОНӨГААТГ	14	40
31	Хөгжил, хөрөнгө оруулалтын газар	13	40
32	Төрийн үйлчилгээний алба	15	40
33	"Буянт хотхон" УТҮГ	23	40
34	Ойн анги	24	40
35	Насан туршийн боловсролын төв	10	40
36	АЙМГИЙН ЗДТГ	33	40
Нийт		717	1440
НИЙТ 49,7% үнэлэгдэж байна.			

3.1 Хууль Тогтоомжийн Сурталчилгаа

Зорилтот гүйцэтгэл : Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах.

Хүснэгт 3. Авилгын эсрэг хууль, тогтоомжийг сурталчилсан байдлын үнэлгээ

Гүйцэтгэлийн үзүүлэлт	Үнэлгээний аргачлал	Зорилтот оноо	Үнэлгээний оноо
1.1 Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/	Цахим хуудсын үнэлгээ Албан газар, мэдээллийн самбарт ажиглалт хийх	36 оноо	4 оноо 11,1%

Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах гэсэн эхний гүйцэтгэлийн үзүүлэлтийг үнэлгээний багийн зүгээс дараах 2 байдлаар шалгаж тодорхой болгосон.

- Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, төсөвт байгууллагуудын албан ёсны цахим хуудсанд “авлигын эсрэг хууль тогтоомжийг нийтэд ил тод болгож байршуулсан эсэх” болон “авлигын эсрэг хууль тогтоомжийг бусад хэлбэрээр олон нийтэд сурталчилсан тухай мэдээ, мэдээлэл оруулсан байдал”-аар нь үнэлгээ өгсөн.

Үнэлгээний нэгдсэн дүнгээр 36-н байгууллагын 4 нь буюу (11,1хувь) ямар нэгэн байдлаар авлигын эсрэг хууль тогтоомжийг олон нийтэд сурталчилж, мэдээлсэн байна. Авлигын эсрэг хууль тогтоомжийг цахим хуудсаараа түгээхдээ тусдаа зориулалтын цэс ашиглах, байнгын баннер байршуулах нь үр дүнтэй ажиглагдлаа. Зөвхөн нэг удаад мэдээлэл оруулаад орхих нь тухайн мэдээлэл хуучирч, архивд шилжсэнээр олон нийтэд хүрэх, ашиглагдах байдлыг муутгаж байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг олон нийтэд түгээхдээ хэвлэмэл материал тараах, олон нийтийн газруудад зурагт самбар байршуулах сошиал орчинд контент нэвтрүүлэг цацах зэрэг нь цаг хугацааны хувьд хүмүүсд хүрэх хүртээмжийн хувьд үр дүнтэй байгаа нь ажиглагдлаа.

3.2 Бодлого Боловсруулалт Дахь Олон Нийтийн Оролцоо

Зорилтот гүйцэтгэл: Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох.

Хүснэгт4. Бодлого боловсруулалтанд олон нийтийн оролцоог хангасан байдлын үнэлгээ

Гүйцэтгэлийн үзүүлэлт	Үнэлгээний аргачлал	Зорилтот оноо	Үнэлгээний оноо
2.1 Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх	Цахим хуудсын үнэлгээ Асуумж судалгаа	72 оноо	57 оноо 79,1%
2.2 Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх			

Шинээр боловсруулж байгаа эрхзүйн баримт бичгүүдийн төсөлд иргэд олон нийтийн санал шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлсэн байдлыг цахим хуудсын үнэлгээнд тулгуурлан дүгнэлээ

Цахим хуудсын үнэлгээний дүнгээр 36-н байгууллагын 29 нь (80,5 хувь) шинээр боловсруулагдаж байгаа эрх зүйн баримт бичгүүдэд санал авахаар цахим хуудсандаа байршуулжээ. Боловсруулагдаж байгаа эрх зүйн баримт бичгийн төслүүдийг цахим хуудсандаа байршуулсан байдлын хувьд 36-н байгууллагын 28 нь (77,7 хувь) биелүүлжээ.

3.3 Хяналтын Үйл Ажиллагааны Ил Тод Байдал

Зорилтот гүйцэтгэл: Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах.

Хүснэгт5. Хяналтын үйл ажиллагааны ил тод байдал

Гүйцэтгэлийн үзүүлэлт	Үнэлгээний аргачлал	Зорилтот оноо	Үнэлгээний дундаж оноо
3.1.Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсандаа байршуулсан байх	Цахим хуудсын үнэлгээ	108 оноо	20 оноо 18,5%
3.2.Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байх /цахим хуудсаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх/			
3.3.Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлсэн байх			
	Асуумж судалгаа		

Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулсан байдлыг цахим хуудсын үнэлгээнд тулгуурлан дүгнэлээ. Үнэлгээний дүнгээр нийт 36 байгууллагын 4 нь (11,1 хувь) цахим хуудсандаа тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг байршуулсан байдалтай байна.

Хяналт шалгалтын төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулсан байгууллагуудын цахим хуудсанд нийтлэг ажиглагдсан зүйл нь “хяналт шалгалтын төлөвлөгөө” гэсэн нэршилтэй үндсэн болон дэд цэсийг нээн ажиллуулж, мэдээлэл оруулсан байгаа явдал юм. Харин төлөвлөгөөг оруулаагүй байгууллагуудын хувьд цахим хуудсанд тодорхой цэсгүй, мэдээлэл оруулах боломж орхигдсон байдал ажиглагдлаа.

3.4 Төсөв, Санхүүгийн Ил Тод Байдал

Зорилтот гүйцэтгэл: Цахим хуудсаар дамжуулан төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх.

Хүснэгт6. Төсөв, санхүүгийн ил тод байдлын үнэлгээ

Гүйцэтгэлийн үзүүлэлт	Үнэлгээний аргачлал	Зорилтот оноо	Үнэлгээний оноо
-----------------------	---------------------	---------------	-----------------

4. 17 дэд гүйцэтгэлийн үзүүлэлт бүхий /Гүйцэтгэлийн үзүүлэлт тус бүрийн үр дүнг дор харуулсан болно. /	Цахим хуудсын үнэлгээ Асуумж судалгаа	576 оноо	361 оноо 62,6%
--	---------------------------------------	----------	---------------------------------


Төсөв санхүүтэй холбоотой дээрх үзүүлэлтийг цахим хуудсын үнэлгээний үр дүнд суурилсан бөгөөд тухайн мэдээлэл байгаа эсэхээс гадна хуулийн хугацаанд мэдээллийг оруулсан эсэхийг харгалзан үзэж үр дүн гаргасан.

Төсөв санхүүтэй холбогдолтой мэдээллийг байгууллагууд цахим хуудсандаа нийтэлснээр нийт 16 оноо авах боломжтойгоос дунджаар 9 оноо авсан байна.

Үнэлгээний нийт дүнгээр 36-н байгууллагаас мэдээлэл оруулсан байдлаар нь хувь тооцож гаргасан үр дүнг доорх дүрсээр та бүхэнд харууллаа.

Дүрс 1. Төсөв санхүүгийн нээлттэй байдлын дэд үзүүлэлтийн үр дүн

САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ



Дээрх үр дүнгээс харахад төсвийн гүйцэтгэлийг сар, улирал, жилээр гаргаж олон нийтэд мэдээлэх байдлын хувьд харьцангуй сайн байгаа нь харагдаж байна. Харин “төсвийн орлого бүрдүүлэлт, тухайн жилийн төсөв гадаадын зээл төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл зэрэг асуудлуудыг цахим хуудсаар олон нийтэд ил болгох тал дээр учир дутагдалтай ажиллажээ.

Зарим байгууллагуудын хувьд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллээ оруулж буй боловч өөрийн албан ёсны цахим хуудсын мэдээллийг шинэчлээгүй тохиолдлууд байна. Үнэлгээний багийн зүгээс цахим хуудсандаа шилэн дансны нэгдсэн цахим хуудасны линкийг байршуулсан тохиолдолд аль аль сайтаас нь мэдээлэл хайж, үнэлгээнд оруулсан болно.

3.5 Зөвшөөрөл Бүртгэлийн Ил Тод Байдал

Зорилтот гүйцэтгэл: Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах.

Хүснэгт 7. Зөвшөөрөл бүртгэлийн ил тод байдлын үнэлгээ

Гүйцэтгэлийн үзүүлэлт	Үнэлгээний аргачлал	Зорилтот оноо	Үнэлгээний дундаж оноо
5.1.Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах	Цахим хуудсын үнэлгээ Асуумж судалгаа	72 оноо	22 оноо 30,5%
5.2.Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа ил тод болгох			

Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрлийн жагсаалтыг байршуулах байдлыг цахим хуудсын үнэлгээний үр дүнд үндэслэн үнэллээ.

Тусгай зөвшөөрөл, лиценз, бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн жагсаалтыг цахим хуудсаараа ил тод болгосон байдал нийт 36 байгууллагын 9-т нь (25 хувь) ажиглагдлаа. Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа ил тод болгосон байдал 31 байгууллагын 13-д (36,1 хувь) байгаа нь дээрх 2 үзүүлэлттэй харьцуулахад хангалтгүй үр дүнг харуулж байна.

3.6 Хүний Нөөцийн Ил Тод Байдал

Зорилтот гүйцэтгэл: Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах.

Хүснэгт 8. Хүний нөөцийн ил тод байдлыг хангасан байдал

Гүйцэтгэлийн үзүүлэлт	Үнэлгээний аргачлал	Зорилтот оноо	Үнэлгээний оноо
6.1.Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах /тухай бүр шинэчилсэн/	Цахим хуудсын үнэлгээ Асуумж судалгаа	72 оноо	29 оноо 40,2%
6.2.Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх			

Байгууллагын сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулсан байдлыг цахим хуудсын үнэлгээний үр дүнг ашиглан гаргасан. Нийт 36 байгууллагын 14 нь (38,8 хувь)

сул орон тоотой холбоотой мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан нийтэд ил болгож байна.

Байгууллагууд сул орон тоотой холбогдолтой зарыг цахим хуудсаар нийтэд мэдээллэхдээ тусдаа үндсэн болон дэд цэс гарган байршуулах нь илүү үр дүнтэй байна.

Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан мэдээлэл түгээсэн байдлыг цахим хуудсын үнэлгээнд тулгуурлан үнэллээ.

Нийт 36-н байгууллагын 15 нь (41,6 хувь) энэ талаарх мэдээллийг нийтэд түгээсэн үр дүнг харуулж байна. Мэдээлэл түгээхдээ дараах аргуудыг түгээмэл ашиглаж байна.

- Орон нутгийн мэдээллийн хэрэгсэл (телевиз, радио)-ээр мэдээлэх
- Цахим хуудсандаа сонгон шалгаруулалтын талаар мэдээлэх

3.7 Худалдан Авах Ажиллагааны Ил Тод Байдал

Зорилтот гүйцэтгэл: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах.

Хүснэгт9. Худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан байдал

Гүйцэтгэлийн үзүүлэлт	Үнэлгээний аргачлал	Зорилтот оноо	Үнэлгээний оноо
7.1.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам /тендер оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт/, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх	Цахим хуудсын үнэлгээ Асуумж судалгаа	180 оноо	48 оноо 26,6%
7.2.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй			
7.3.Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах			
7.4.Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах			
7.5.Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх			

Худалдан авах ажиллагааны ил тод байдлын 1-5 дах гүйцэтгэлийн үнэлгээг цахим хуудсын үнэлгээнд тулгуурлан үр дүн гаргасан.

Байгууллагуудын цахим хуудсанд худалдан авах ажиллагааны мэдээллийг оруулсан байдлын үр дүнг дараах дүрсээр харууллаа.

Дүрс2. Худалдан авах ажиллагааны ил тод байдлын мэдээлэл

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ



Дээрх үр дүнгээс харахад худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүн, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах зэргийг бусад үзүүлэлтээс өндөр хувьтай цахим хуудсандаа байршуулжээ. Харин бусад гурван үзүүлэлтийг хангалтгүй байршуулжээ.

3.8 Албан Хаагчдын Ажил Үүргийн Хуваарь

Зорилтот гүйцэтгэл: Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох.

Хүснэгт 10. Албан хаагчдын ажил үүргийн хувиарыг тодорхой болгосон байдал

Гүйцэтгэлийн үзүүлэлт	Үнэлгээний аргачлал	Зорилтот оноо	Үнэлгээний дундаж оноо
8.1. Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох	Цахим хуудсын үнэлгээ	72 оноо	59 оноо 81,9%
8.2. Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх			

Албан хаагчдын ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгосон байдлыг цахим хуудсын үнэлгээний дүнгээр тодорхойлсон. Нийт 36-н байгууллагын 29 нь (80,5 хувь) цахим хуудсандаа ажилтнуудын хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг оруулсаар байгаа нь бусад үзүүлэлттэй харьцуулахад илүү эерэг үр дүнг харуулж байна.

3.9 Удирдлагын Шийдвэрийн Ил Тод Байдал

Зорилтот гүйцэтгэл: Цахим хуудсандаа байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах.

Хүснэгт11. Удирдлагын шийдвэрийн ил тод байдлын үнэлгээ

Гүйцэтгэлийн үзүүлэлт	Үнэлгээний аргачлал	Зорилтот оноо	Үнэлгээний дундаж оноо
9.1 Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах	Цахим хуудсын үнэлгээ Асуумж судалгаа	108 оноо	61оноо 56,4%
9.2 Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах			
9.3 Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах			

Удирдлагын шийдвэрийн ил тод байдлын талаарх 4-н гүйцэтгэлийг цахим хуудсын үнэлгээнд суурилан гаргалаа.

Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх тал дээр байгууллагууд нэлээд сайн ажилласан байна. Нийт 36 байгууллагын 30 нь (83,3 хувь) удирдлагын шийдвэрийг цахим хуудсаараа ил тод болгосон байна.

3.10 Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үнэлгээ

Зорилтот гүйцэтгэл: Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах.

Хүснэгт12. Иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн үнэлгээ

Гүйцэтгэлийн үзүүлэлт	Үнэлгээний аргачлал	Зорилтот оноо	Үнэлгээний дундаж оноо
10.1 Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх	Цахим хуудсын үнэлгээ Асуумж судалгаа	108 оноо	56 оноо 51,8%
10.2 Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон			

мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах			
10.3 Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх			

Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байдал 36 байгууллагын 29-д (80,5 хувь) биелэгдсэн болох нь цахим хуудсын үнэлгээнээс харагдаж байна. Ялангуяа цахим хуудсанд өөрийн эрхлэх асуудлын хүрээг тодорхойлж нийтэд мэдээлсэн байдал сайн үр дүнтэй байна.

3.11 Авилгын эрсдэлийг бууруулах боломж, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Зорилтот гүйцэтгэл : Байгууллагуудын авилгын эсрэг авч хэрэгжүүлж байгаа бодлого хөтөлбөр иргэдэд төрийн байгууллагын ажилчидаар дамжин хүрч байгаа бөгөөд үүний үр дүнд иргэд сэтгэл хангалуун төрийн байгууллагын ажилчид болон иргэд ямарваа нэгэн хохирол амсахгүй байх.

Нийт судалгаанд хамрагдсан иргэд авилга байгаа шалтгааныг

- I. Төрийн байгууллагын ажилчдын хүнд суртал
- II. Шудрага бус зан
- III. Ажилчдын хандлага ёс зүй
- IV. Бага цалин хөлс гэж үзэж байна.

Дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэнээр авилга буурах боломжтой гэж үзэж байгаа бөгөөд Үүнд :

- Удирдлага, ажилчид шудрага байх
- Байгууллагын санхүү, үйл ажиллагаа ил тод байх
- Ажилтанд тавих шаардлага нэмэх
- Ажилчдын цалинг нэмэгдүүлэх
- Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах
- Хяналт шалгалт нэмэгдүүлэх
- Авилгын эсрэг сургалт сурталчилгааг илүү үр дүнтэй хийх зэрэг нь авилгыг бууруулна гэж үзэж байна.

3.12 Удирдлагын Авилгатай Тэмцэх Хүсэл Эрмэлзлэл


Зорилтот гүйцэтгэл: Тухайн байгууллагын удирдлага ашиг сонирхлоос ангид байх авилгын эсрэг ажилчидтайгаа хамтран үйл ажиллагаа хэрэгжүүлэх аливаа дотоод асуудлууд нээлттэй байхаар ажиллах

Дүрс3. Удирдлагын ашиг сонирхолын талаарх үнэлгээ



Байгууллагын одоогийн удирдлагын ашиг сонирхлын зөрчлийн үнэлгээнд 36-н байгууллагын 258 ажилчидын 200 нь (77,5 хувь) удирдлагаа ашиг сонирхлын зөрчлөөс ангид гэж боддог, 51 нь (20 хувь) ашиг сонирхлын зөрчлөөс бүрэн ангид хүн гэж хэлж чадахгүй байгаа гэсэн үзүүлэлт гарч байна.

Дүрс4. Удирдлага өөрийн хувийн ашиг сонирхолын холбогдолтой болон авлигын асуудлаар ажилчиддаа аливаа нэг шаардлага тулгалт үзүүлсэн үнэлгээ



Мөн одоогийн удирдлага өөрийн хувийн ашиг сонирхолын холбогдолтой болон авлигын асуудлаар ажилчиддаа аливаа нэг шаардлага тулгалт үзүүлж байсан эсэх дээр нийт ажилчдын (2.01 хувь) ямар нэг шаардлага тавьж байсан, (16.2 хувь) хариулахаас татгалзаж үлдсэн (81,7. хувь) ямар нэг шаардлага тулгалт үзүүлж байгаагаа гэсэн хариултыг өгсөн байна.

Байгууллагууд авилгатай тэмцэх, авилгын эсрэг дараах ажлуудыг голчлон хийсэн байна. Үүнд :


- Сургалт сурталчилгаа авах болон өөрсдөө сургалт хийх

- Улс, аймгийн зарласан аянуудад нэгдэх
- Тодорхой хэмжээнд төлөвлөгөө гарган ажилладаг гэсэн хариултыг өгсөн бөгөөд энэ нь нийт судалгаанд хамрагдсан хүмүүсийн 30 хувийг эзэлж байна.

3.13 Төрийн байгууллагуудын ил тод, шудрага байдлын үнэлгээ


Зорилтот гүйцэтгэл : Төрийн байгууллагууд үйл ажиллагааны хувьд ил тод, ажилчдын харилцаа хандлага зөв байх

Дүрс5.Иргэд төрийн байгууллагуудын бодлого шийдвэрүүдийн ил тод байдлыг үнэлсэн үнэлгээ




Нийт иргэдийн 96 хувь нь төрийн байгууллагын бодлого шийдвэр ил тод бус байдаг гэж үзэж байгаа нь маш муу үзүүлэлт болж байна.

Дүрс5.Төрийн байгууллагын ажилчдын хүнд суртал иргэдийн санал бодлын үнэлгээ



Иргэдийн төрийн байгууллагуудын авилгад өртөх тэргүүлэх шалтгаанд ажилчдын хүнд суртал багтаж байна.

Дүрс6. Өмнөговь аймагт хууль иргэн бүрт тэгш үйлчилдэг эсэх иргэдийн төрийн үйлчилгээнд өгсөн үнэлгээ



Хууль ёс хүн бүрт тэгш үйлчилдэггүй гэх хариулт нийт оролцогчдын 80.9хувийг эзэлж байгаа нь хангалтгүй байгаа үзүүлэлт гэж байна.

4.ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

“Өмнөговь аймгийн 2022 оны авилгын эсрэг үйл ажиллагааны хөндлөнгийн үнэлгээ” судалгааны ажлыг Өмнөговь аймгийн Даланзадгадын нутаг дэвсгэрт байрлах 36 нэгж байгууллагын 250 төрийн албаны ажилтан, 750 иргэд нийт 1000 иргэдийг хамруулан мэдээлэл цуглуулж ажиллаа.

Судалгаанд оролцсон нийт иргэдийн үнэлгээгээр авилга, шудрага байдлын үнэлгээ 50.8 хувьтай дундаж үр дүн гаргаж байна. Үнэлгээ муу үзүүлэлттэй гарсан гол шалтгаан иргэдээс авсан судалгаан дахь аймгийн авилгын түвшинг тодорхойлох үнэлгээ буюу байгууллагаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгч иргэдийн үнэлгээ байсан.

Иргэдийн үнэлгээ болон цахим орчны үнэлгээнээс харахад байгууллагын ил тод байдалд чухал анхаарч ажиллах, ажлын тайлан төсөл, хөтөлбөр, тендэр зэрэг байгууллагын дотоод дүрэм журам байгууллагын дотоод нууцаас бусад мэдээллийг нээлттэй тодорхой байршуулж мэдээлэх тал дээр түлхүү ажиллахаар байна.

Удирдлагын шудрага байдлын үнэлгээ буюу байгууллагын дотоод шудрага байдлын үнэлгээ хангалтгүй гарах шалтгаан нь авилгын эсрэг тогтолцоо хангалтгүй, байгууллагын удирдлага ажилчдын хоорондын итгэлцэл муу, байгууллагын ажилчдын иргэдэд үйлчлэх хандлага хүнд суртал, зэргээс шалтгаалж байна.

Байгууллагын дотоод харилцааг нэмэгдүүлэх, цахим орчин олон нийтэд үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, ажилчдын хувь хүний ёс суртахуун, шудрага байдалд анхаарч ажиллах, ажилтан шалгаруулж авах шаардлагыг илүү хувь хүний хүмүүжил ёс суртахуунд тулгуурлаж авах шаардлагатай байна.

Үнэлгээг байгууллагаар авч үзвэл Эрүүл мэндийн газар (БОЭТ), Мэргэжлийн хяналтын газар, Боловсролын газар, Төрийн захиргааны байгууллага(аймаг, сумын тамгын газар), Татварын хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар зэрэг байгууллагууд хамгийн өндөр буюу хангалтгүй үнэлгээг авсан байна.

Цахим үнэлгээнд хамрагдсан 36 байгууллагын авсан үнэлгээ 20-72.5 хувийн хооронд байгаа нь цаашид үнэлгээг нэмэгдүүлэх чиглэлээр анхаарал хандуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Цахим орчинд мэдээллээ бүрэн оруулах шилэн дансны мэдээлэл нээлттэй ил тод байх зэрэг дээр анхаарч иргэдэд тогтмол үйл ажиллагаа мэдээлж цахимаар дамжуулан хүргэх шаардлагатай байна.

Байгууллагуудын авилгын эсрэг авч хэрэгжүүлсэн ажил ажилчдаас авсан судалгаагаар 52.3 хувь ажил арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй гэх үзүүлэлт гарч байгаа бөгөөд үлдсэн хувьд хийгдсэн үйл ажиллагаа сургалт болон улс, аймгийн аянд нэгдсэн байдлаар илэрч байгаа нь хангалтгүй үзүүлэлт гарж байна.

Шудрага байдал авилгын эсрэг үнэлгээг сайжруулах хүрээнд төрийн байгууллагуудын хувьд ил тод байдал, авилгын эсрэг тэмцэх хүсэл эрмэлзлэл, авилга хянах механизмыг сайжруулах, байгууллагуудын удирдлага болон ажилчдын хувь хүний ёс суртахуун, нийгмийн хэргэцээнд дэмжлэг үзүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна. Мөн байгууллагын дотоод хяналт, аудитын үйл ажиллагаанд анхаарч ажиллах нь зүйтэй юм.

6.ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

№	Агентлаг, төсөвт байгууллагуудын нэрс	Тус бүрийн оноо	Нийт оноо
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	25	40
2	Биеийн тамир, спортын газар	8	40
3	Боловсрол, шинжлэх ухааны газар	25	40
4	Гаалийн алба	0	40
5	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	25	40
6	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	23	40
7	Мал эмнэлгийн газар	25	40
8	Мэргэжлийн хяналтын газар	30	40
9	Нийгмийн даатгалын хэлтэс	22	40
10	Онцгой байдлын газар	28	40
11	Орон нутгийн өмчийн газар	12	40
12	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	27	40
13	Соёл, урлагийн газар	8	40
14	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	21	40
15	Статистикийн хэлтэс	26	40
16	Татварын хэлтэс	26	40
17	Улсын бүтргэлийн хэлтэс	26	40
18	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	23	40

19	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	14	40
20	Хүнс, хөдөө аж ахуйн газар	11	40
21	Цагдаагийн газар/вэб,пэйж хуудас/	29	40
22	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	15	40
23	Шүүхийн шинжилгээний алба	23	40
24	Эрүүл мэндийн газар	26	40
25	Авто тээврийн үндэсний төвийн өмнөговь аймаг дахь салбар	25	40
26	Музей	23	40
27	Хөгжимт жүжгийн театр	22	40
28	Номын сан	23	40
29	Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газар	14	40
30	Даланзадгад зорчигч тээвэр ОНӨГААТГ	14	40
31	Хөгжил, хөрөнгө оруулалтын газар	13	40
32	Төрийн үйлчилгээний алба	15	40
33	"Буянт хотхон" УТҮГ	23	40
34	Ойн анги	24	40
35	Насан туршийн боловсролын төв	10	40
36	АЙМГИЙН ЗДТГ	33	40
НИЙТ 49,7% үнэлэгдэж байна.			

АЖИЛТДААС АВАХ АСУУМЖ СУДАЛГАА

Таны амгаланг айлтгая.

Говь Эвент ХХК нь Өмнөговь аймгийн Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэсээс “Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх” санал зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү санал асуулгыг явуулж байна. Төрийн албанд хууль ёс, шударга байдлыг сахин ажиллаж, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж, улс орноо хөгжүүлэх, өргөсөн тангарагтай төрийн албан хаагч таны санал бодол авлигагүй төрийн албыг цогцлооход амин чухлыг ухамсарлан, бидний ажилд чин сэтгэлээсээ тусална гэдэгт итгэж байна.

Жич: Та нэрээ бичих шаардлагагүй, өгсөн мэдээллийн нууцыг бид чандлан хадгалах болно.

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Таны нас:
2. Таны хүйс? 1. Эрэгтэй 2. Эмэгтэй
3. Таны мэргэжил: 4. Таны албан тушаал:
.....
4. Төрийн албанд нийт хэдэн жил ажилласан бэ?
5. Тус албан тушаалд та хэдэн жил ажиллаж байна вэ?
6. Тус албан тушаалд томилогдохоос өмнөх албан тушаал:
.....

ХОЁР. УДИРДЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТАЛААРХ ҮНЭЛГЭЭ

7. Танай байгууллагын одоогийн удирдлагын ашиг сонирхлын байдлын талаар таны бодол?
 1. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид хүн
 2. Ашиг сонирхлын зөрчлөөс бүрэн ангид хүн гэж хэлж чадахгүй
 3. Ашиг сонирхлын зөрчилтэй хүн
8. Танай байгууллагын одоогийн удирдлага өөрийн хувийн ашиг сонирхлын холбогдолтой болон авлигын асуудлаар танд шахалт үзүүлж байсан тохиолдол бий юу?

№	Тохиолдлууд	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1	Хувийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх асуудлаар шийдвэр гаргуулахаар шахалт үзүүлж байсан	1	2	3
2	Илэрхий авлига, хээл хахуулийн шинжтэй шийдвэр гаргуулж байсан	1	2	3
3	Цаад утгаараа авлига, хээл хахуулийн шинжтэй шийдвэр гаргуулж байсан	1	2	3
4	Бусад ажилчдад хувийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх зорилгоор шийдвэр гаргуулахаар шахалт үзүүлснийг би мэднэ.	1	2	3
5	Цаашид авлига, хээл хахуулийн шинжтэй шийдвэр гаргуулах магадлалтай хүн гэж би боддог.	1	2	3
6	Бусад (бичнэ үү)	1	2	3

9. Та өөрийн ажиллаж буй байгууллагын даргын авлигын эсрэг үйл ажиллагаа болон түүний зан байдлыг дараах нөхцөлүүдээр хэрхэн үнэлэх вэ?

№	Нөхцөлүүд	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1	Тэр өөрөө авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт, санаачилгатай байж чаддаг	1	2	3

2	Тэр авлигын эсрэг арга хэмжээний санхүүжилтийн асуудлыг дэмжин шийдвэрлэдэг	1	2	3
3	Тэр байгууллагын бусад албан хаагчдыг авлигыг үл тэвчих хандлагад уриалж чаддаг	1	2	3
4	Тэр авлигаас ангид байх хандлагыг өөрийн зан байдлаар үзүүлж, бусдад үлгэрлэж чаддаг	1	2	3
5	Танай байгууллагаас томилогдсон Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай хамтран ажиллаж, үйл ажиллагааг нь дэмждэг эсэх?	1	2	3
6	Танай байгууллагын дарга тухайн жилийнхээ “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг дүгнэж, хамт олондоо тайлагнадаг уу?	1	2	3
7	Танай байгууллагын дарга тухайн жилийнхээ “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хамт олноороо дүгнүүлж, ажилчидад “Авлигын эсрэг үйл ажиллагаа”-г нээлттэй, ил тод байх тал дээр анхаарч, хамтран ажилладаг уу?	1	2	3
8	Танай байгууллагын дарга иргэд, олон нийтэд байгууллагынхаа “Авлигын эсрэг үйл ажиллагаа”-тай холбоотой мэдээллийг нээлттэй, ил тод байлгах тал дээр анхаарч ажилладаг уу?	1	2	3

10. Танай байгууллагаас 2021 оноос хойш авлигатай тэмцэхэд зориулж зохион байгуулсан ажлуудаас товч дурдана уу?

№	Ажлын нэр, зорилго, агуулга	Хамрах хүрээ	Огноо	Үр дүн

11. Таны бодлоор танай байгууллагын одоогийн удирдлага хэр шударга хүн бэ?

1. Шударга гэж хэлж чадна
2. Шударга гэж бүрэн дүүрэн хэлж чадахгүй
3. Шударга гэж огт хэлж чадахгүй

12. Та өөрийгөө энэ байгууллагын дарга гэж төсөөлбөл авлигын эсрэг ямар үйл ажиллагааг юуны өмнө санаачлан хэрэгжүүлэх вэ? Яагаад? Байгууллагын “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-д өөрчлөлт оруулах, сайжруулах саналуудыг дурдана уу?

№	Хийгдэх ажлууд	Яагаад?
1		
2		
3		

13. Таны бодлоор авлигыг дэмжин дэлгэрүүлэхэд нөлөөлж буй гол хүчин зүйл юу вэ?

.....
14. Таны бодлоор авлигыг хориглоход чиглэсэн ямар ажил, шийдвэр шаардлагатай байна вэ?

.....
15. Авлигыг дэмжин дэлгэрүүлэхэд нөлөөлж буй заншил, ёс суртахууны ямар хүчин зүйлүүд байна гэж та бодож байна вэ?

ТАНД БАЯРЛАЛАА

ИРГЭДЭЭС АВАХ АСУУМЖ СУДАЛГАА

Таны амгаланг айлтгая.

Говь эвент ХХК нь Өмнөговь аймгийн Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэсээс “Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх” санал зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү санал асуулгыг явуулж байна. Төрийн албанд хууль ёс, шударга байдлыг сахин ажиллаж, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж, улс орноо хөгжүүлэх, өргөсөн тангарагтай төрийн албан хаагч таны санал бодол авлигагүй төрийн албыг цогцлооход амин чухлыг ухамсарлан, бидний ажилд чин сэтгэлээсээ тусална гэдэгт итгэж байна.

Жич: Та нэрээ бичих шаардлагагүй, өгсөн мэдээллийн нууцыг бид чандлан хадгалах болно.

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Таны нас:

2. Таны хүйс? 1. Эрэгтэй 2. Эмэгтэй

Таны боловсролын түвшин :

Таны ажил эрхлэлтийн байдал :

Таны сарын орлого :

**ХОЁР. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
 ДЭРГЭДЭХ ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГА АГЕНТЛАГУУДЫН АВЛИГЫН
 ТҮВШИН**

1.Таны бодлоор авлигыг дэлгэрүүлэгч хүчин зүйл юу вэ?

.....

2.Таны ажил, амьдрал болон ойр дотны хүмүүст авлига авч, өгөх явдал тохиолдож байсан бол үйлчилгээний ямар байгууллагад вэ?

.....

3.Таны бодлоор авлигыг хориглоход чиглэсэн ямар ажил, шийдвэр шаардлагатай байна вэ?

.....

4.Авлигыг дэмжин дэлгэрүүлэхэд нөлөөлж буй зан заншил, ёс суртахууны ямар хүчин зүйлүүд байна гэж та бодож байна вэ?

.....

5.Аймгийн удирдлага бодлого боловсруулахдаа иргэд, олон нийтийн оролцоог чухалчилдаг уу?

.....

№	Нөхцөлүүд	Сайн	Дунд	Үгүй
1	Та аймгийн төсөвт байгууллага агентлагуудын төсөв, санхүүгийн ил тод байдлыг үнэлнэ үү	1	2	3
2	Та аймгийн төсөвт байгууллага агентлагуудын зөвшөөрөл бүртгэлийн ил тод байдлыг үнэлнэ үү	1	2	3
3	Та аймгийн төсөвт байгууллага агентлагуудын хүний нөөцийн ил тод байдлыг үнэлнэ үү	1	2	3
4	Та аймгийн төсөвт байгууллага агентлагуудын албан хаагчдын ёс зүйн дүрмийг үнэлнэ үү	1	2	3
5	Та аймгийн төсөвт байгууллага агентлагуудын үйлчилгээний шударга байдлыг үнэлнэ үү	1	2	3
6	Та аймгийн төсөвт байгууллага агентлагуудын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг үнэлнэ үү	1	2	3
7	Та аймгийн Төрийн албан хаагчдын шударга байдлыг үнэлнэ үү	1	2	3

13.Аймгийн удирдлагын бодлого шийдвэрүүдийн ил тод байдал

1.Маш муу 2.Муу 3.Дунд зэрэг 4.Сайн 5.Онц сайн

14.Аймгийн Төрийн байгууллагуудын хүнд суртал

1.Маш их 2.Харьцангуй их 3.Дунд зэрэг 4.Харьцангуй бага 5.Маш бага

15.Аймгийн Төрийн албан хаагчдын авлигад өртөх байдал

1.Маш их 2.Харьцангуй их 3.Дунд зэрэг 4.Харьцангуй бага 5.Маш бага

16.Аймгаас зарлаж буй тендерүүд ил тод, шударга байж чаддаг эсэх

1.Огт чаддаггүй 2.Чаддаггүй 3.Чаддаг 4.Сайн чаддаг 5.Бүрэн чаддаг

17.Аймагт хууль ёс хүн бүрт тэгш ...

1.Огт үйлчилдэггүй 2.Үйлчилдэггүй 3.Үйлчилдэг 4.Сайн үйлчилдэг 5.Бүрэн үйлчилдэг

ТАНД БАЯРЛАЛАА

ЦАХИМ ХУУДСАНД ҮНЭЛГЭЭ ХИЙХ

№	Шалгуур үзүүлэлт	Хариулт /1-тийм, 2-үгүй/	Нэмэлт тайлбар
---	------------------	-----------------------------	----------------

1	1.1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/		
2	2.1.Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх		
3	2.2.Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх		
4	3.1.Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсандаа байршуулсан байх		
5	3.2. Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байх /цахим хуудсаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх/		
6	3.3.Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлсэн байх		
7	4.1. Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/		
8	4.2. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/		
9	4.3. Сарын төсвийн гүйцэтгэл /дараа сарын 8-ны дотор/		
10	4.4. Улирлын төсвийн гүйцэтгэл /дараа сарын 8-ны дотор/		
11	4.5. Хагас жилийн төсвийн гүйцэтгэл /8 дугаар сарын 15-ны дотор/		
12	4.6. Хагас жилийн санхүүгийн тайлан /8 дугаар сарын 15-ны дотор/		
13	4.7. Дараа жилийн төсвийн төсөл /9 дүгээр сарын 15-ны дотор/		
14	4.8. Жилийн эцсийн санхүүгийн тайлан /4 дүгээр са-рын 25-ны дотор/		

15	4.9. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /4 дүгээр сарын 25-ны дотор/		
16	4.10. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /7 дугаар сарын 1-ний дотор/		
17	4.11. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар /улирал бүр/		
18	4.12. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт /өөрчлөлт орсноос хойш ажлын 7 хоногийн дотор/		
19	4.13. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох / татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл /		
21	4.14. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт /гүйлгээ хийснээс хойш 7 хоногийн дотор/		
22	4.15. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт / өөрчлөлт орсноос хойш 7 хоногийн дотор /		
23	4.16.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл		
24	5.1.Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрлийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах		
25	5.2.Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа ил тод болгох		
26	6.1.Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах /тухай бүр шинэчилсэн/		
27	6.2.Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх		
28	7.1.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам /тендерг оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт/, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх		

29	7.2. Гендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулах		
30	7.3. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах		
31	7.4. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах		
32	7.5. Гендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх		
33	8.1.Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох		
34	8.2.Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа мэдээлсэн байх		
35	9.1.Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэрийг цахим хуудсандаа байршуулах		
36	9.2.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах		
37	9.3.Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах		
38	10.1. Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх		
39	10.2.Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах		

40	10.3.Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх		
----	--	--	--